



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 520

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авч бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хувийн хэвшлийн хуулийн этгээд болон иргэд өөрсдийн хүсэлтээр төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн, нийт 1,213,247,700.00 (нэг тэрбум хоёр зуун арван гурван сая хоёр зуун дөчин долоон мянга долоон зуу) төгрөгийн балансын үнэ, 1,075,496,112.03 (нэг тэрбум далан таван сая дөрвөн зуун ерэн зургаан мянга нэг зуун арван хоёр төгрөг гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002404
23-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн
588 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Байршил	Үнэ төлбөргүй шилжүүлэх өгч буй хуулийн этгээдийн нэр
1	Ган яндан хоолой Ф400мм	2002	56	хос метр	15,018,100.00	13,616,410.67	1,401,689.33	Баянгол дүүрэг 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 3 дугаар эмнэлгийн урд байрлалтай	Техник импорт ХК болон бусад компаниудын (дундын эзэмшлийн)
2	Ган яндан хоолой Ф400мм	2006	751.2	хос метр	418,080,600.00	418,080,600.00	-	Хан-Уул дүүрэг 18-р хороо удирдлагын академийн гудамж "Суруга салаа 2х400 хос шугам	"Суруга Монгол" ХХК
3	Ганбөмбөлгөн хаалт	2006		хос метр	242,750,000.00	242,750,000.00	-		
4	Ган яндан хоолой Ф400мм	2006	707.5	хос метр	537,399,000.00	401,049,101.36	136,349,898.64		
Нийт дүн					1,213,247,700.00	1,075,496,112.03	137,751,587.97		
					(нэг тэрбум хоёр зуун арван гурван сая хоёр зуун дөчин долоон мянга долоон зуу)	(нэг тэрбум далан таван сая дөрвөн зуун ерэн зургаан мянга нэг зуун арван хоёр төгрөг гурван мөнгө)	(нэг зуун гучин долоон сая долоон зуун тавин нэгэн мянга таван зуун наян долоон төгрөг жаран дөрвөн мөнгө)		